

МОНГОЛ УЛСЫН УУЛЫН ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ БА НЭРШИЛ

Т.Түмэндэмбэрэл

“Уул”-ыг физик-газарзүйн үүднээс “тэгшивтэр газарт сүндэрлэсэн, тал бүрдээ тодорхой үзэгдэх хормойтой өндөрлөг” хэмээн тодорхойлжээ (Цэгмэд, УБ., 1972:30). Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 2/3 хувь нь уулархаг бөгөөд 1600 м-ээс дээш өндөр уулс бүх нутгийн 32.4 хувийг эзэлдэг (Гунгаадаш, УБ., 1969: 15). Өөрөөр хэлбэл, монгол оронд уул олон байх нөхцөлтэй ажээ. Тиймээс монгол нүүдэлчид уулын тогтоц, хэлбэр, өнгөөр нарийвчлан ялгаж нэрлэдэг байна. Энэхүү илтгэлд тэрхүү шинж тэмдэг, онцлог зүйлийг тодорхой жишээгээр тайлбарлах болно.

“Уул” гэсэн нэрийг Монголын нутаг болгонд өөр өөрөөр нэрлэх нь бий. Жишээбэл: уулархаг бүсийн зон олон уулыг “толгой”, “толгод” хэмээн нэрлэж байхад говь-хээрийн бүс дэх ард түмэн өндөрлөг газраа “уул” гэж дууддаг. Үүнээс авч үзэхэд уулыг нэрлэхдээ нутаг нутгийн хүмүүсийн ахуй орчин, байгалийн тогтоц, байршилаас хамаарч өөр өөрөөр нэрлэдэг байна. “Монгол газар нутгийн нэрийн цахим сан” (Равдан, УБ., 2003)-д Алтай, Хангайн уулархаг их муж дахь аймгуудад уулын нэр олон, харин Говь-хээр, Хянганы их муж дахь аймгуудад уулын тоо нь цөөн байна. Тухайлбал, Хөвсгөл аймагт 5109, Завхан аймагт 4424, Архангай, Говь-Алтай аймагт 2700 уулын нэрийн тус тус тэмдэглэсэн байхад Говь-хээр, Хянганы их мужийн аймгууд болох Дорноговь, Сүхбаатарт дундчаар 500 уулын нэр байна.

Бид өгүүлэлдээ дээрх санд багтсан 38 224 уулын нэрийг нарийвчилсан тусгай дэд цахим санд оруулан гарсан зарим үр дүнг нь доор ашиглав. Уулыг аймгуудаар нь авч үзвэл: Архангайд 2773, Баянхонгорт 2424, Баян-Өлгийд 2025, Булганд 2202, Говь-Алтайд 2708, Дорнодод 774, Дорноговьд 573, Дундговьд 724, Өвөрхангайд 1209, Өмнөговьд 1090, Завханд 4415, Сүхбаатарт 489, Сэлэнгэд 2355, Увсад 2114, Улаанбаатарын дүүрэгт 209, Ховдод 2302, Төв аймагт 2379, Хөвсгөлд 5109, Хэнтийд 2350 уулын нэр тус тус орсон байна.

Монголчууд уулаа шинж төрх, байршил, өнгө, өндөр нам зэргээр маш олон янзаар ялган нэрлэдэг байна. Үүнд: *аараг, адарга, айраг, ам, ан, ангал, антлага, ар, асга, ац, багалзуур, багана, байц, барзан, барчин, богоч, божолиг, болдог, боодог, боом, борзон, боролж, босго, бөөрөг, булдруу, булуу, бураа, гацаа, гозгор, гувруу, гудаа, гуя, гувээ, гүдгэр, гүдэн, гурдгэр, гээг, дав, даваа, дачан, дов, доvon, доvцог, дөрөлж, дош, дугуй, дух, дүмбэн, дүхэн, дэв, дэвсэг, дэл, дэн, дэнж, дэнжиг, дэх, жирэм, зааг, завсар, залаа, зоо, зүдгэр, зураа, зээг, ирмэг, лах, магнай, майхан, манхан, матага, мөргөцөг, мөргүү, мөрөг, мудаа, мухар, нахис, нахиу, нураг, нурган, нуруу, нүүр, овгор, овоо, огстроого, онь, оорцог, оргил, орой, өвдөг, өвөр, өлгий, өндөр, өндөрлөг, өнцөг, садарга, салаа, сэнж, сархиа, сархид, сарьдаг, сондог, сондуул, суварга, суга, сүв, сүвээ, сүүл, сэрвэн, сээр, тавилан, таг, танхан, таргил, тарлаг, тархи, тасархай, ташуу, товгор, товог, товоо, тогоо, толгод, толгой, торлог, төвөө, төрлөг, төхөм, туруу, туурь, түнгэ, түрүү, тэжлэг, тэнгэр, тэсэг, тээг, уул, ухаа, үзүүр, хаачга, хаваг, хавирга, хавтас, хавцал, хавчиг, хавчуу, хад, хажуу, халбан, хальтирлаг, хамар, ханан, хацар, хаяа, хаячаг, хирвэс, хонгил, хонх, хорго, хормой, хошуу, хөв, хөвөө, хөвч, хөвөөр, хөл, хөмөг, хөмрөг, хөтөл, хур, хургад, хуруу, хуудас, хузүү, хүзүүвч, хүрд, хүрэм, хүрээ, хэв,*

Т.Түмэндэмбэрэл
МУИС

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

хэдмэг, хэжлүүр, хэжлэг, хэм, хэрэм, хэц, хянга, хяр, хясаа, цав, цайдам, цалуу, царам, цахир, цонж, цоорхой, цорго, цохио, цүлхэн, цүнхэг, цэнэ, чулуу, шан, шанаа, шанд, шил, ширээ, шовгор, шовдол, шовон, шовх, шон, энгэр, эрэгцэг, эх, явар болно. (Равдан, 2008: 31).

Дээрх уулыг шинж тэмдгээр нь ялган нэрлэсэн дэвсгэр нэрэнд нутгийн аялгууны болон энгийн ярианы өнгө аястай цөөнгүй нэр орсон байна. Жишээлбэл: (нахиу - нахис - онь - богоч; дэн - дэнж - дэв; уул - гозгор, өндөр - түнтгэр - мөндгөр гэх мэт). Тэдгээрээс “Онь”-ыг авч үзэхэд “онь” гэж монголчууд “уулын хярын сэтэрхий, нахиу, нам хэсэг”-ийг (Цэвэл, УБ., 1966, 419) хэлдэг. Тэгвэл “онь”-ийг Баруун Монголын дөрвөд, баяд, хотонгууд НАКО, захчин, өөлд, торгууд, урианхай нар НАКУ, НАКАЗ “нахиу”, “нахид” гэж нэрлэдэг байна. “Нахиу” дээрээ намаржаатай гэж ойрд ардын дуунд өгүүлсэн байна (Цолоо, 1999. 648-р тал).

Түүнчлэн монголчууд нүүдэлчдийн ахуйгаасаа уламжлан уулын бэлээс орой, оргил хүртэлх бүхий л биетэд өөр өөр нэр оноож нэрлэдэг. Жишээ нь: уулын бэл, ар, өвөр, энгэр, хормой, хондлой, мөр, тархи, оргил, сүмбэр гэх мэтчилэн нэрлээд, уулын орой, шовх хэмээн нэрлэн дууддаг байх юм. Тэрхүү олон нэр нь “уул” ухагдахууныг бүрэлдүүлэгч утгалбар болно. Нөгөөтэйгүүр, дээрх нэр бүр Монгол газар нутгийн дэвсгэр нэрийн санд давтагдах байдлаараа өөр өөр байна. Одоо бид энд зөвхөн уулын зарим төрлөөс зарим жишээ татан өгүүлье.

Монголчууд олон мянган жилийн турш мал аж ахуй эрхлэн нүүн шилжин амьдрах явцдаа байгаль орчноо ажиглан шинжиж, харьцуулан жишиж тунгаан, зааглан нэрлэж ирсэн бөгөөд нэн ялангуяа уулын өвөрмөц тогтоц, байршил, оройн хэлбэр, дүрс, өнгө үзэмжээр нь нарийвчлан нэрлэдэг эртний уламжлалтай. Жишээлбэл, уулыг өвөрмөц тогтоц, байршлаар нь зүйлчилэн *САРЬДАГ*, *ХӨВЧ*, *ЯН*, *НУРУУ*, *ХЯР*, *ЗОО*, *ЦАРАМ*, *ХҮЙС*, *ООРЦОГ*, *ОНЦ*, *СОНДГОЙ*, *ХАЙДАГ*, *ШОВХ*, *ШИЙР*, *ГОЗГОР*, *ХАЙРХАН* гэх мэт болно. “САРЬДАГ” уул гэдэг нь оройдоо зун орой болтол цастай (Догсүрэн, УБ., 1987: 93) эсвэл мөнхийн цастай оргил бүхий мод ургамалгүй хадан (Казакевич, М., 1934: 22; Цэвэл, УБ., 1966: 472) уулыг монголчууд сарьдаг гэж тусгайлан нэрлэдэг байна. Харин “ХӨВЧ” уул нь үргэлжилсэн ба эгнэсэн уул нурууг хэлнэ. Хөвчийг Я.Цэвэл аругай: “уул нуруу зэргийн үргэлжилсэн газар: уул хөвч, хангай хөвч” (Цэвэл, УБ., 1966:703) гэсэн бол Ц.Норжин: дээрх тодорхойлолтыг давтаад “хөвч бүрхсэн ой” гэсэн утгалбарыг нэмж өгсөн байна (Норжин, Хөххот, 1999: 1515, Ж.Цолоо (1988, УБ., 584)-д нэг нь үргэлжилсэн уулс, нөгөө нь битүү ой болно гэж тус тус тодорхойлсон байдаг. Дээрх Сарьдаг, Хөвч уулын жишээнээс тусгайлан ялган авч, задлан үзэхэд энэ хоёр уул нэг нь нөгөөгөөсөө өөр, өвөрмөц тогтоц, тодорхой байршилд суурилсан, өөр өөрийн онцлог ялгархуйц шинж, бүрэлдхүүнтэй байна.

Уулс нь оройн хэлбэр, харагдах байдлаараа өөр өөр байдаг. Жишээ нь, шовх, шөмбөгөр, бөмбөгөр, гэдгэрдүү, тогоо шиг, тэгш, хавтгай, ширээ шиг, мөлгөр шувтан, дөрвөлжин, гурвалжин гэх мэт оройтой уул олон байдаг. Одоо эдгээр олон янзын хэлбэртэй уулын оройг харьцуулан авч үзье.

“БӨМБӨГӨР” хүртээл нэр орсон уулын нэр бидний цахим санд нийт 80 байна. Түүнээс *Бөмбөгөр уул 9*, түнтгэрийн ижил ялгамж нэр авсан нь 5 байна. Гэтэл *Бөмбөгөр толгой* нийт 27 тэмдэглэгдсэн нь “бөмбөгөр” гэж уулыг нэрлэхээсээ илүү толгойг нэрлэдэг гэж болохоор ажээ. Байршлын тухайд гэвэл өмнө бидний тэмдэглэсэн судлаач Ч.Догсүрэнгээс “өмнө зүгийн зарим нутагт” гэсэн нь мөн хараахан тохирохооргүй байна. Тухайлбал, *Бөмбөгөр Дух уул*, *Бөмбөгөр Цахир уул* Увсын Зүүнхангай суманд, *Бөмбөгөр уул* Архангайн Тариат, Хотонт, Хөвсгөлийн Тариалан, Бүрэнтогтох, Хэнтийн Өлзийт, Өмнөдэлгэр суманд, *Бөмбөгөр толгой* Завханы Түдэвтэй, Тэлмэн, Дөрвөлжин, Сантмаргац, Булганы Сайхан, Баян-Агт, Говь-Алтайн Эрдэнэ, Увсын Цагаанхайрхан, Архангайн Эрдэнэмандал, Чулуут, Хөвсгөлийн Алаг-Эрдэнэ, Арбулаг, Цагаан-Уул, Тосонцэнгэл зэрэг аймаг суманд бий. Тиймд тодорхой бүс нутгаар дээрх нэрийн байршлыг заах боломжгүй байна.

“ТЭВШ” нэртэй уул бидний цахим санд дэвсгэр нэрээр тэмдэглэгдээгүй болно. Харин оноосон гишүүний үүргээр тэр нь нийт 112 нэрэнд *тэви*, *тэвийн*, *тэвшингийн*, *тэвшит*, *тэвшитийн* гэсэн хэлбэрээр дараах дэвсгэр нэртэй хоршин хэрэглэгджээ. Үүнд: *ам 6*, *булаг*, *говь 3*, *гол*, *доролж*, *дэвсэг*, *жалга*, *нуруу*, *нуур*, *сайр 4*, *сархиа*, *тал*, *товгор*, *тойром*, *толгод*

2, толгой 25, тээг, уул 25, ухаа 6, хамар, хонхор5, хоолой 2, хөндий, хөтөл, худаг 14, хүрэм, хяр 4 болой. Эдгээрээс тэвш хэлбэртэй уул, түүний тухайт нэрийг ялган үзвэл: Тэвш толгой 25, Тэвш уул 25, Тэвш толгод 2, Тэвш дэвсэг тус бүр нэжгээд бүртгэгджээ. Энэхүү баримт нь тэвшийн тухай хийсэн бидний тайлбар зохистой болохыг нотолж байна.

Түүнчлэн монголчууд уулыг байрлал, хэлбэр, дүрс зэргээс гадна өнгөөр нь бие эрхтэнтэйгээ дүйлгэн нэрлэх нь нэлээд түгээмэл. Бидэнд байгаа баримтаас үзэхэд наад зах нь элэг, уушги-ийн шилжсэн утгаар нь уулын өнгийг оноосон нэрэнд тусган нэрлэдэг ажээ.

“ЭЛЭГ” (ЭЛГЭН) уул гэж хүрэн өнгийн уул, толгодыг нэрлэдэг болохыг бид хээрийн шинжилгээний судалгааны ажлын явцад тогтоосон болно. Овооны Элэг уул Хөвсгөлийн Жаргалант, Өндөр Элэг толгой Хөвсгөлийн Бүрэнтогтох, Цагаан Элэг толгой Өвөрхангайн Богд суманд тус тус бий. Харин Элэгэн уул Дундговийн Луус, Гурвансайхан, Төв аймгийн Баянцагаан, Говь-Алтайн Алтай, Бигэр, Булганы Гурванбулаг, Сүхбаатарын Сүхбаатар, Өмнөговийн Баяндалай, Номгон, Ханбогд, Баянхонгорын Баян-Өндөр, Дорноговийн Айраг, Мандах, Хатанбулаг суманд нийт 14 нэр бидний Тольд бүртгэгджээ.

“УУШГИ” уул гэж улаан, улаавтар өнгөтэй барзгар уулыг гол төлөв нэрлэдэг. “Уушги” нь монгол газар нутгийн нэрд мөн түгээмэл хэрэглэгддэг. Тэр нь “уушги”, “уушгай” гэсэн хос хэлбэрээр тааралддаг бөгөөд утгын гарваль нь ижил болой. Дээрх хоёр нэр орсон 180 орчим оноосон нэр Тольд тэмдэглэгджээ. Түүнээс “уул” нь 60-аад байна (Равдан. УБ., 2008: 48).

Монгол улсын уулсын байршил ба нэршлийг хэлний бодит баримтаар авч үзвэл уулсын нэр нь газар зүйн бүс мужлал, байршил, орон нутгийн онцлог шинжтэй холбоотой байгаа нь ажиглагдав. Түүнчлэн уулын түгээмэл зарим нэршил нь монгол утга соёл, аман болон бичгийн уран зохиол, монгол хүний сэтгэлгээний онцлог зэрэгтэй холбогдож байна.

Дээрх хоёр дүгнэлтээс хураангуйлбал, монгол улсын уулсын нэр нь байршилтайгаа, байр байршил нь оноосон нэртэйгээ гүн нарийн уялдаатай, хоор хоорондоо утга агуулга, шинж төрх, гарал үүслээрээ нэгдмэл нэг тогтолцоотой байна. Тиймээс Монгол улсын уулсын нэршил байрлалын судалгаа нь зөвхөн газарзүйн судалгаанд холбогдох төдийгүй монгол хэл, монгол аман билиг, монгол хүний сэтгэлгээний онцлог зэрэгтэй гүнзгий холбоотой байгаа тул энэ нь утга соёлын цогц судалгаа болно.

НОМЗҮЙ

Гунгаадаш Б. Монголия сегодня, М., 1969

Дашдаваа Д. Равдан Э. Нэр томъёоны тухай, УБ, 1980

Догсүрэн Ч. Монголын газар усны нэрийн тогтолцооны зарим асуудалд-“Studia Mongolica”, 10 fasc.17 УБ, 1975., 243-251 с.

Догсүрэн Ч. Орчин цагийн монгол хэлэнд дэх уулын тухайт нэр томъёо - “Хэл зохиол” XVI боть УБ, 1987, 92-97

Казакевич В.А Современная монгольская топонимика Л., изд. Акадетий наук СССР, 1934, 1-29

Равдан Э. Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь 1970-1980, Хариуцан эрхэлсэн Э.Равдан 8 дэвтэр, CD2-ийн хамт, УБ., 2004

Равдан Э. Монгол газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн судалгаа, УБ., 2004, 322х

Равдан Э. Хэл шинжлэлийн түүхийн товчоон, УБ, 2005, 206 х.

Цолоо Ж. БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг - “Ойрад аялгуу”, УБ., 1988

Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь УБ., 1966

Цэгмэд Ш. БНМАУ-ын физик газар зүй. УБ., 1972

SUMMURY

Our research concluded that 38,224 place names are related with/coincide with their local region, mountain formation and zone, as well as, that the meaning, symbol and/or origin of the place name reflect the ideology, linguistic style, ethnicity and culture of Mongolia.